

Рөүси өөрийгөө нэгэн хэсэг нь биш гэж мэдрэхээс залхаж байв.



# Рөүсигийн залбирал

Люси Стивэнсон Ивэлл  
(Бодит түүхээс сэдэвлэв)

Рөүси үүргэвчээ шалан дээр хаяв. Шинэ ангид аа ороод ердөө хоёр хонож байлаа. Өнөөдөр тийм ч сайхан өдөр байсангүй.

“Юу болоо вэ?” гэж ээж нь асуув.

Рөүси буйдан дээр лаг хийн суугаад “Манай ангийн зарим хүүхэд надад миний бор арьсны талаар муухай зүйл хэлсэн” гэв.

Сургуульд нь Рөүсигийнхтэй ижил арьсны өнгөтэй хүмүүс тийм ч олон байгаагүй тул түүнд тэрээр тэдний нэг хэсэг нь биш мэт санагдаж байлаа. Гэвч түүнийг шоолсон нь байдлыг улам бүр дордуулсан юм.

Ээж нь санаа зовнисон байдалтай “Надад харамсалтай байна” гэж хэлээд, түүнийг тэврэн “Би энэ талаар багштай

чинь ярих болно” гэж нэмж хэлэв.

Дараагийн өдөр нь ч сургууль дээр түүнийг дахин гоочлов. Ангийнх нь нэг хүү түүнтэй өдөржин муухай харьцав.

Рөүси гунигтай, бас ууртай байлаа. Заримдаа өөртэй нь бүдүүлэг харьцахад Рөүси хариу маргалддаг байв. Гэхдээ энэ нь түүнд тус болсонгүй.

Нэг өдөр Рөүси сургуулиасаа гэртээ ирээд шууд өрөө рүүгээ гүйн оров. Тэр шоолуулахаас залхжээ. Рөүси өөрийгөө нэгэн хэсэг нь биш гэж мэдрэхээс залхаж байв. Тэр дэрэндээ нүүрээ наан уйлав.

Би юу хийх ёстой вэ? гэж бодлоо. Тэр үлдсэн хичээлийн жилийн турш ийм мэдрэмжтэй байхыг хүссэнгүй.

Рөүси нулимсаа арчаад, номын тавиур дээрх Есүсийн бяцхан баримал руу харав. Ээж нь үүнийг Рөүсид Есүсийг санахад туслахаар өгсөн юм.

Магадгүй би залбирах ёстой байх гэж тэр бодлоо. Тэр өвдөг сөхрөөд, гараа энгэртээ зөрүүлэв.

“Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, миний сэтгэл маш их шархалж байна. Манай ангийнхан намайг бор арьстай болохоор шоолдог.

Энэ нь надад аймшигтай санагддаг. Надад туслаач” гэж тэр залбирлаа.

Тэнгэрлэг Эцэгт сэтгэлээ уудлан ярихад түүнд сайхан байв. Тэрээр өөрийг нь сонсож байгааг Рөүси мэдэж байлаа. Зөөлөн хөнжлөөр өлгийдүүлж байгаа мэт дулаан мөн хайрыг тэр мэдрчээ. Тэр өөрийнх нь арьсны өнгө үзэсгэлэнтэй гэдгийг мэдрэв. Тэр Бурханы хүүхэд бөгөөд Тэр түүнд хайртай гэдгийг мэдэв.

Рөүсиг залбирч дуусахад түүнд нэг санаа төржээ. Магадгүй тэр сургуульдаа туслах ямар нэг зүйлийг хийж чадах байх.

Дараагийн долоо хоногт Рөүси ээжийнхээ хамт сургуулийнхаа удирдлагуудтай ангид нь юу болж байгаа талаар ярилцав. Рөүси сургууль дээрээ дээрэлхүүлж байсан өөр хүүхдүүдийг хайж олоод, тэдэнтэй найзалж эхлэв. Тэр өөрийг нь шоолж байсан хүүг тоохгүй байхыг хичээж байлаа. Ням гарагт сүм дээр тэрээр Тэнгэрлэг Эцэг хүн бүрд хайртай гэсэн гэрчлэлээ хуваалцав.

Сургуулийн байдал тэр даруй дээрдээгүй ч Рөүси хүнд хэцүү санагдвал залбирах үед нь ямар мэдрэмж төрснийг санадаг. Тэр Бурханы хүүхэд бөгөөд Бурхан Түүнд хайртай. Тэр үүнийг мэдсэн учраас юуг ч хийж чадна. ●



## АРЬС ӨНГӨӨР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ҮЗЛИЙГ ҮГҮЙ ХИЙХ РӨҮСИГИЙН ЗӨВЛӨМЖ

**АРЬС ӨНГӨӨР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ** гэдэг нь арьсны өнгө, гарал үүслээс нь болж хүмүүстэй шударга бусаар харьцах явдал юм. Юу хийж болох талаараа суралц.

- Бурханы хүүхэд гэдгээ сана.
- Хүн бүхэнтэй хайраар, эелдэг мөн хүндэтгэлтэй харьц. Тэд ч бас Бурханы хүүхдүүд гэдгийг бүү март.
- Хэрэв чи өөрөө дээрэлхүүлж байгаа эсвэл хэн нэгний дээрэлхүүлж байгааг харвал насанд хүрсэн хүнтэй ярилц. Өөрийнхөө төлөө зогс, гэхдээ өөрт чинь хандсан шиг эелдэг бус зангаар бүү харьц.
- Бусадтай туршлагаа хуваалц. Тэдэнд ганцаараа биш гэдгээ мэдэхэд нь тусал.
- Шударга бус байдалтай нүүр тулж байгаа бусад хүний төлөө зогс. Тэдний найз бол.



ЗУРАГ ЧИМЭГЭЛЛИЙГ ШОНА Ж.КЭТЭНИ